

XX зууны монголын хөрөг зургийн дүр, дүрслэлд хийсэн зарим ажиглалт

Т.Сэлэнгэ

МУБИС, Дүрслэх урлаг технологийн сургууль, Дүрслэх урлагийн тэнхим

Хураангуй

Хөрөг зураг нь дүрслэх урлагийн томоохон салбарын нэг. Хөрөг зургийн онцлог нь гол төлөв түүхэн бодит хүний төрх байдлыг уран сайхны дүрээр дамжуулан гаргадагт оршино. Монгол хөрөг зургийн үүсэл нэлээд олон зуун жилийн өмнөх үед холбогдох ба тэр эрт цагаас түүний үе бүхэнд өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоор хөгжсөөр зурж урлах онол дүрэм, арга барил, дүрслэл, илэрхийлэл, гүйцэтгэлийн нэгдсэн тогтолцоонд хүрчээ. Зөвхөн гадаад хэлбэр төдийгүй тухайн хүний үзэл бодол, зан араншин, дотоод ертөнц, түүнчлэн утсаа гарал, хэргэм зэрэг, албан тушаал, ажил мэргэжил, эрдэм боловсролын зааг ялгааг ч хөрөг зурагт тодорхой нарийн дүрслэн үзүүлдэг. Дээрхээс илүүд зурагт үзүүлэх зүйл бол тухайн үеийн этоци, сэтгэл хөдлөл нэн чухал. Тиймд хөрөг зургийг нарийвчлан судлахад сэтгэл судлалын нөлөө их.

Эцэст нь, зураач бүрийн дотоод сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэл бодол, үзэл бодол, илэрхийлэл зэрэг нь хөрөг бүрд шингэсэн байна. Хөрөг бүтээлд аливаа хүний давтагдашгүй дүр төрх, зан чанар, сэтгэл санаа, онцлог шинжээр нь зогсохгүй түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, нийгэмд эзлэх байр суурийг тодотгон дүрсэлдэг. Тиймдээ ч түүхийн үнэт болохын сацуу, уран бүтээлчийн чанар чансааг тодорхойлох томоохон шалгуур гэж ойлгож болно.

Түлхүүр үг

Хөрөг зураг, интерпретацийн арга, дүр, дүрслэл, зураач

Удиртгал

XX зууны монголын зарим хөрөг зургийн дүр, дүрслэлийн онцлогийг нарийвчлан судлахад оршино.

Судалгааны арга зүй

Урлагийн бүтээл бүр дотоод гадаад гоо зүйн хэм хэмжээсээр бүрддэг ба тэднийг тайлж унших нь энгийн хүнд тун бэрх. Бүтээл бүрийн үнэ цэнэ, юу агуулж байна, ямар сэтгэл зүйн факт туссан зэргийг нарийвчлах үүднээс интерпретацийн аргыг хэрэглэлээ.

Интерпретацийн арга гэдэг нь interpretation буюу тайлбарлах, боловсруулалт, утга гэсэн утгатай англи нэр томъёолол юм. Энэхүү арга урлаг судлалд нэн чухал арга бөгөөд урлагийн бүтээлийг концепци, үзэл санаагаар нь тусган тайлал хийхийг хэлнэ. Бүтээл бүр өөрийн гэсэн үзэл суртал, үнэ цэнийг агуулдаг хэдий ч тухайн зураачийн сэтгэл зүй хамгийн их байна.

Нэг талыг хамарсан үзэл баримтлал: Зураачийн намтар, түүх болон бусад хүчин зүйлийн талаарх мэдлэг нь урлагийн бүтээлд үнэлэлт өгөхөд ач холбогдол тун бага.

Олон талыг хамарсан үзэл баримтлал: Тухайн уран бүтээлчийн амьдарч байсан үе, цаг хугацааны үзэл санаа, тухайн үзэл санааны

талаарх зураачийн үзэл бодол, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал зэрэг олон зүйл нөлөөлдөг байна. Уран бүтээлийг нягт ойлгоход олон талыг хамарсан үзэл баримтлал буюу олон талт судалгаа зайлшгүй шаардагдаж байна. Тийм ч учраас нэг сэдвийн хүрээнд олон талт судалгааг хийхийг зорьсон болно.

Урлагийн аливаа төрөл нь хүнийг хүмүүжүүлэх, урамшуулах, амьдралд хөлөө олох, нийгэм ертөнцөө танин мэдэх, ер нь аливаа зүйлийг ялган салгаж ухамсарлан ойлгох явдалд тусалдгаараа гайхамшигтай юм. Нэн ялангуяа хөрөг бүтээлээс хүний сайн сайхныг тунгаан авч, саар муухайг таягдан хаях боломжтой. Хэрэв театр, киноны жүжигчид дүрийг бүтээхдээ үг яриа, үйл хөдлөлөөрөө хүний мөн чанарыг үзүүлээд өгдөг бол зураачид энэ бүхнийг өнгө дүрслэлээр үзэгчдэд хүргэх хүндхэн үүрэг гүйцэтгэдгээрээ ялгаатай. Хөрөг зургийн онцлог нь гол төлөв түүхэн бодит хүний төрх байдлыг уран сайхны дүрээр дамжуулан гаргадагт оршино. Зөвхөн гадаад хэлбэр төдийгүй тухайн хүний үзэл бодол, зан араншин, дотоод ертөнц, түүнчлэн угсаа гарал, хэргэм зэрэг, албан тушаал, ажил мэргэжил, эрдэм боловсролын зааг ялгааг ч хөрөг зурагт тодорхой нарийн дүрслэн үзүүлдэг. Монгол уран зургийн бие даасан нэгэн төрөл /жанр/ бол хөрөг зураг

юм. Хөрөг бүтээлд аливаа хүний давтагдашгүй дүр төрх, зан чанар, сэтгэл санаа, онцлог шинжээр нь зогсохгүй түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, нийгэмд эзлэх байр суурийг тодотгон дүрсэлдэг.

Зорилго нь тухайн хүний дүр төрх, зан чанар, тэр байтугай сэтгэлийн байдлыг харуулах нь хөрөг зургийн гол зорилго оршдог. Зурагт үзүүлэх зүйл бол тухайн үеийн этоци, сэтгэл хөдлөл нэн чухал. Тиймд хөрөг зургийг нарийвчлан судлахад сэтгэл судлалын нөлөө их байдаг. Тухайн зураачийн сэтгэлгээ зуруулж буй хүний сэтгэц хоёрын харилцан хамаарлын үр дүнд хөрөг үүсдэг гэж ойлгож болно.

Монгол хөрөг зургийн үүсэл олон зуун жилийн өмнөх үед холбогдох ба тэр цагаас өөр өөрийн өвөрмөц онцлогтойгоор хөгжсөөр зурж урлах онол дүрэм, арга барил, дүрслэл, илэрхийлэл, гүйцэтгэлийн нэгдсэн тогтолцоонд хүрчээ. Социализмын үед хөрөг зургийг баяжуулахад хэрэг болох деталиудыг нягт дүрслэхийг үгүйсгэдэггүй байв. Тэр деталь хэсгүүд нь ерөнхий утга агуулга өнгө аястайгаа нэгдэн зохицож байжээ. Тиймдээ ч хөрөг зураг бол реализмын төгс илэрхийлэл юм. Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч П.П.Чистяков, “Зураач ажигласнаа зөвхөн жирийн хуулбарлах биш юмсын үндсэн шинж, уг чанар, зүй тогтлыг ойлгож түүнийгээ нэгтгэн дүгнэж дүрсэлдэг юм” хэмээн бодит зургийг тайлбарласан байдаг. Харин Философич Аристотель, “Урлагийн зорилго нь гаднах шинж чанарт бус бодит байдлыг бүрдүүлэхийн тулд дотоод ач холбогдлыг харуулах зорилготойгоор бүтээгдэх ёстой” хэмээн тайлбарласан байдаг (Одон нар. 1988, х.49). Дээрхээс үзэхэд бодит зургийн амин сүнс нь дотоод сэтгэлгээний илэрхийллийг дүрслэхэд оршдог. Өөрөөр хэлбэл хөрөг зургийн онцлог нь гол төлөв түүхэн бодит хүний төрх байдлыг уран сайхны дүрээр дамжуулан гаргадагт оршино. (Цанжид.А . 2007) Зөвхөн гадаад хэлбэр төдийгүй тухайн хүний үзэл бодол, зан араншин, дотоод ертөнц, түүнчлэн утсаа гарал, хэргэм зэрэг, албан тушаал, ажил мэргэжил, эрдэм боловсролын зааг ялгааг ч хөрөг зурагт нарийн дүрслэн үзүүлдэг. XX зууны Монголын хөрөг зураг нь уран бүтээлийн хөргөөс гадна хүн нийгмийн хэрэгцээний дагуу бүтсэн захиалгат хөргийн төрлөөр хөгжиж байжээ. Тодруулбал, техник технологийн хөгжил хурдацтай хөгжөөгүй байсан нь зарим тохиолдолд нас барсан хүний хөрөг зурах шаардлага хэрэгцээ тулгарч байсан ба үүнийг хэрэгцээний дагуу хөгжиж байсан хөрөг гэж үзсэн болно. Гэвч энэхүү хөргийг захиалгын хөрөг бүтээлтэй адилтгаж болохгүй. Захиалгын хөрөг нь тухайн нийгэмд

эзлэх байр суурь өндөр, нэрд гарсан хүмүүсийг олонд таниулах, сурталчлах зорилгоор хөгжиж байсан ба ухуулан сурталчлах хэлбэрийг давхар агуулж байжээ. XX зууны эхэн, дунд үеийн уран бүтээлүүдийн гол сэдэв нь нам, ард түмний түүх, Монгол Зөвлөлтийн ард түмний найрамдал, ялалт амжилт, манай орны тусгаар тогтнол гэх мэт олон арван сэдэв байлаа. Тэдгээрийн дотроос хувьсгалт баатарлаг хүмүүсийн хөрөг голлох байртай байсны нэг нь В.И.Ленины хөрөг юм. В.И.Ленин хөрөг, аж байдлын сэдвээр голчлон бүтээхдээ зурагт хуудсанд багагүй дүрсэлсэн. Учир нь тухайн үед ухуулан сурталчлах зурагт хуудас хөгжлийн дээд төвшинд хөгжиж байсан ба ардын намын бодлогыг Ленин багшийн сургаалаар хэрэгжүүлж буй гол санааг магтан дуулж байсан байна. Тухайлбал: Зураач Ц.Даваахүү “Энхтайван” /81x61/ 1970 оны бүтээлд энхийн цагаан тагтаатай хослуулсан цэнхэр өнгийн захирамжаар зурсан нь зургийн нэртэй аргагүй хослох мэт. Өнгөт барын арга ажиллаагаагаар бүтээгдсэн уг бүтээл нь зурагт хуудсын урлагт өөрийн гэсэн орон зайг илэрхийлэхүйц томоохон ажлын нэг юм. Гуаш цаасыг ашиглан, улаан өнгийн дагнаасаар бүтээгдсэн уг бүтээл бол зураач Л.Дашзэвэгийн “Лениний үзэл санаа мөнх” /86x62/ хэмээх 1983 оны зураг юм. Зурагт хуудсын урлагт ерөнхий утга санааг бүтээлийн дээр шууд бичих нь элбэг байсан нь эгэл ардад ухуулан сурталчлахад дөхөм байжээ. Жишээ нь дээрх хоёр бүтээлээс гадна зураач Б.Гомбосүрэн “Мөнх улаан зул” /105x75/ 1959 оны бүтээл. Мөн зураач С.Цэрэндоржийн “Октябрь” /59x84/ 1970 он, С.Мижиддорж “Хоршооллын төлөвлөгөө Монгол оронд” /71x110/ 1971 он гэх зэрэг олон бүтээл туурвижээ.

Зураг 1

Ү.Ядамсүрэн, “Өвгөн хуурч”, 1958



XX зууны Монголын урлагт Монгол зургийн аргаар дүрсэлсэн хөрөг онцгой байр суурь эзэлдэг. Ү.Ядамсүрэн нь монголын дүрслэх урлагийн түүхэнд их, бага хэмжээний 50 гаруй хөрөг бүтээн үлдээсэн байдаг. Түүний зурсан хөргүүд эгэл жирийн ард иргэдээс төрийн нэрт зүтгэлтэн хүртэлх нийгмийн олон давхаргыг тусгасан байдаг. 1930-1940-өөд оны уран зурагт ардын хувьсгалын тухай болон түүхт хүмүүсийн дүрийг бүтээхэд гол анхаарлаа хандуулах болсон. “Өвгөн хуурч” бүтээл нь уран нарийн зураас, зураасаар баяжигдан бэлгэдэл утга агуулгыг үндэсний хээгээр илэрхийлсэн байна. Үндсэн цэвэр өнгө, тэгш хэмийн зохиомжтой дүрслэгдсэн ба монгол зургийн арга хэрэглэгдэхүүнээр зурагдсан боловч тосон будгийн ололтоор баяжигдсан нь хөргийн салбарт үнэтэй хувь нэмрийг оруулсан юм.

Уран сайхны дүрийн дотоод сэтгэлгээг тод гаргасан энэ хөрөгт туульч, ерөөлч, хуурч хүний ерөнхий намба төрх, хэв шинжийг чадмаг илэрхийлснээс гадна монголын угсаатны зүй, уламжлалт урлагийн өв санг магтан гайхуулсан бүтээл юм. Бүтээлийн натурт Гандангийн хувраг байсан Цэрэннадмид гэж хүнийг суулгажээ. Хөргийн эд хэрэглэл, хувцас зэрэгт үндэсний уламжлалт хээ, угалзаар чимэглэсэн байгааг харж болно. Хос луун хээтэй дээл өмсгөж, өмд дээр нь байгалийн гаралтай хээг зохиомжилсон байна.

Арын шаргал фон дээр арсланг үүлэн хээн дээр дүрсэлсэн ба хэсэг бүр нарийн мэдрэмж, ур шаардсан нь илэрхий харагдана. Монголын уламжлалт хээ угалзыг эд хэрэглэл дээр нь бүрэн шингээж, өвгөн хуурчийн намба төрх, дотоод сэтгэлийн илэрхийллийг гайхалтай харуулсан XX зууны шилдэг бүтээл билээ.

1.Төр, нийгмийн зүтгэлтнүүдийн хөрөг:

XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн монголын урлаг нь иргэний хандлагатай зураг, ардын уламжлалт бүтээлүүд хүчтэй нөлөөлж эхэлж байсан хэмээн судлаач Н.Цүлтэм онцолсон байдаг. (Төмөрбат, 2010) Тэрхүү хөгжлийн заагаас уран бүтээлээрээ тодрон гарч, ардын хувьсгалын үзэл санааг хамгийн түрүүн хүлээн авч амьдрал, уран бүтээлээ холбосон зураач бол Б.Шарав юм. “В.И.Лениний хөрөг” бүтээл нь Октябрын хувьсгалын ач нөлөөгөөр Монгол ардын хувьсгал ялж феодализмаас социализмд дэвших гэрэлт ирээдүйг нээн өгсөн хувьсгалт ардчилсан шатны үеийн дүрслэх урлагийн гол бүтээл юм. Тухайн үед ухуулан сурталчлах зураг илүү хөгжиж байсан ба бүтээлүүдийн зорилго нь улс төрийн бодлоготой нягт холбоотой байв. Тиймдээ ч Лениний хөрөг нь

нам засгийн захиалгын зураг билээ. Орос улсын агуу удирдагч В.И.Ленинг дэлхийн багш хэмээн тунхаглахыг хүссэн уг хөрөг нь тэгш хэмийн зохиомжтой ба эв нэгдэл, найрамдлын бэлгэдлийг агуулжээ.

Зураг 2

Шарав “В.И.Лениний хөрөг” 1922



Өнгийн гэрэл сүүдэр, рефлекс гэх мэт өрнийн урлагийн аргаар зурсан мэт харагдавч сайтар ажиглавал хүрээлбэр зурлагаар зурсан буюу монгол зургийн арга ажиглагддаг. Үүнээс үзэхэд “В.И.Ленины хөрөг” уран зураг нь Монгол зургийн аргыг Өрнийн уран зургийн аргатай хослуулсан анхдагч бүтээлүүдийн нэг юм. Улаан туг нь эв найрамдлын бэлгэдэл хэмээн үзэж болно. Тэмцэн бадарч буй байдлыг тодотгох үүднээс гал улаан өнгөөр тугаа дүрслээд дээд талд нь таван хошуун дээр нь арга билэг хоёрыг байрлуулжээ. Мөнхөд орших гэсэн далд утгыг арга билгээрээ илэрхийлж, бадамлянхуа цэцгээр доод буланд чимсэн нь хүндэтгэлийг агуулсан байна. Зураачийн хөрөг бүтээлүүдэд нэг өнгийн тоноор эзлэхүүнийг чадамгай шийдэж, бөс даавуу, нугалаа атирааг уран гаргадаг, биет юмсын бодит чанарыг харуулдгаараа онцлог.

2. Харандаан будгаар зурсан хөрөг:

Ц.Бүдбазарын “Хүүгийн хөрөг” /1961он/ бүтээл нь хар зургийн арга ажиллагаагаар хүүхдийн ерөнхий дүрийг гадаад болон дотоод сэтгэлийг нээн харуулсан бүтээл юм. Бодит хэллэгээр зурсан энэхүү хөргийн гэрэл, сүүдрийн харьцааг техник ажиллагаагаар чадмаг гаргаж өгсөн байна. Тухайлбал: Унасан, ойсон гэрэл, нюанс зэргийг харандаан ажиллагаагаар илэрхийлэхдээ хүнд хөнгөн даралтаар зуржээ.

Хүүгийн хөргийн нүүрийг нарийвчлан ажиллаж хэсэг бүрийг авч үзсэн боловч эх бие болон бусад хэсгийг дутуу орхисон нь учиртай ба

энэ нь зургийн улам бүр баяжуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл үзэгч бодит зурсан нүүрийн хэсэг рүү анхаарал шууд харах боломжийг нээн өгсөн гэж ойлгож болно.

Зураг 3

Ц.Бүдбазар “Хүүгийн хөрөг” /1961 он



Нүүрэн дээрхи гэрэл
сүүдрийн ялгамжийг
тодотговол: Гялаан гэрэл,
үндсэн сүүдэр, хүнд сүүдэр,
хагас сүүдэр, ойсон гэрэл,
унасан сүүдэр гэсэн үндсэн
зургаан элементээс бүрдсэн
байна.

Усан будгаар дүрслэгдсэн хөргүүд

Зураач Ц.Доржпаламын усан будгийн ажлууд нь шингэн, тунгалаг өнгөөр биетийн донж төрх, хэлбэр хэмжээг чадмаг илэрхийлсэн бүтээлүүд байдаг. Хөнгөн тон дээр ханасан бичилтээр баяжигдсан уг хөрөгт нүүрний илэрхийлэлд зан араншин нь гүн туссан буйг олж харж чадна. Өвгөний ширүүн, догшин харцыг удаан ширтвэл гуниг тээсэн бодлогоширсон байгааг анзаарна. Манаргалт, уусгалт, бичилт гэх мэт усан будгийн арга ажиллагааг гэрэл сүүдрийн захирамжаар дүрслэхдээ хүйтэн дулаан өнгийг харилцан уялдаатай нэгтгэн ажилласнаар онцлогтой.

Зураг 4

Ц.Доржпалам,
“Хүзүүндээ эрхтэй
өвгөн”



Зураг 5

Ц.Доржпалам, “Ногоон
дээлтэй өвгөн”



Бичилт бүр биетийг бүрэн илэрхийлэхүйц чадмаг зурснаас гадна устай шингэн, тунгалаг

ажилласан байна. Урлагийн бүтээл бүр дахин давтагдашгүй чанар үргэлж агуулж байдаг. Учир нь бүтээлд зураачийн ертөнцийг үзэх үзэл, уран сэтгэмж сэтгэмж, дотоод сэтгэхүйн нөлөө, төсөөлөн бодох чанар, сэтгэл зүйн нөлөөлөл, зан араншин гэх мэт мөн чанар болон бусад зүйл нь гүн тусдаг тул үнэ цэнийг өөртөө агуулж чадсан байдаг. Хөрөг зурагт дээрх зураачийн сэтгэл зүйгээс гадна зуруулж буй хүний сэтгэлийг судлах зайлшгүй тулгардаг. Тиймдээ ч зөвхөн гаднах төрхийг нь зурснаар хөрөг зураг болохгүй. Мөн дээрх онцлог болон ажиллагаа зэрэг “Ногоон дээлтэй өвгөн” бүтээлд туссан байдаг.

3. Тосон будгаар дүрслэгдсэн хөргүүд

Эгэл ардын дундаас тодорсон хөдөлмөрчин хүмүүсийн хөрөг

XX зуунд түүхэндээ гавьяа байгуулсан эсвэл олны танил нэрт зүтгэлтэн, ажилчид, сайн малчид, жүжигчин бүжигчин зэрэг соёл урлагийн нэрт төлөөлөгчдийг магтан дуулсан бүтээлүүд их төрсөн. Тэдгээрийн нэг нь зураач Б.Мөнхөөгийн зурсан “Хөдөлмөрийн баатар Санж” юм. Одон тэмдгээ энгэртээ зүүж мал сүргийг нь хойно нь зохиомжилсон ба гэрэл сүүдрийг биетийн ракусаар сайн илэрхийлжээ.

Зураг 6

Б.Мөнхөө,
“Хөдөлмөрийн баатар
Санж”, 1973



Зураг 7

Б.Мөнхөө, “Малчин
Дарьсүрэн”, 1975



Б.Мөнхөө “Малчин Дарьсүрэн” -Энгэртээ Монголын залуучуудын Эвлэлийн тэмдэг зүүсэн эгэл даруу залуухан бүсгүйн хөрөг Б.Мөнхөө зураачийн хөрөг дундаас шууд нүд туслаа. Цонхны наана суулган хурган дотортой дээл өмсгөсөн энэхүү бүсгүйн нүд хийгээд нүүрний илрэл нэгийг бодогдуулах мэт. Хэсэг бүрд нягт ажилласан хөргийн цаана алслагдан хөрөг дэх тэмээн сүрэг түүнийг тэмээчин гэдгийг харуулсан ба хүйтэн тон цонхны цаанаас бүдэгхэн үзэгдэнэ.

Үзэгчдийн анхаарлыг бүсгүйн дүрлийсэн нүд, цэгцтэйхэн суусан биеийн хэл рүү шууд татах зорилгоор зурсан нь зохиомжийн төвд авснаас харагдана. Реалист арга ажиллагааг зарим хэсгээр нягт, үлдсэн хэсгийг том том бичилтээр шийдсэн байна. Сайн малчин бүсгүйн үзэсгэлэнг урлагт мөнхлөхийн зэрэгцээ урын сангаа баяжуулж чадсан уг бүтээл хөрөг зургийн хөгжилд өөрийн гэсэн өнгө төрхийг үлдээж чадсан байна.

Соёл урлаг, нийгмийн талбарт онцгой үүрэг гүйцэтгэж байсан зүтгэлтнүүдийн хөрөг
Зураач С.Дондогийн зурсан “Жамьяан хуурч” уран зураг нь гэрэл сүүдрийг бодит тусгаж, зан төлөв, хүний зан араншинг бүрэн илэрхийлсэн хөрөг зураг юм. Мөн ХХ зууны дийлэнх хөргүүд нь ажил мэргэжил, гавьяа цолыг нь дөвийлгөн дүрсэлдэг байсны тод жишээ нь уг хөрөг бүтээл билээ.

Зураг 8

С.Дондог, “Жамьяан хуурч”, 1982



Хажуу талаас нь хурц гэрэл тусгаснаар нүүрний гэрэл сүүдэр нь улам тодорч, нягт нямбай бус зарим хэсгээр ерөнхий бичилтээр дүрсэлжээ. Өөрөөр хэлбэл нүүрний бичилт нь хүйтэн дулаан өнгөөр гэрэл сүүдрийг шаглан бичсэн бол их бие, арын фон зэргийг ерөнхийлөн зурсан байна.

Зураг 9

Г.Одон, “Ардын жүжигчин Ичинхорлоо”, 1952 он



ХХ зууны алдарт жүжигчин, дуучин Ичинхорлоог дүрсэлсэн уг хөрөг зураг нь Г.Одон зураачийн урыг илтгэсэн шилдэг хөргүүдийнх нь нэг юм. Алдарт жүжигчин эмэгтэйн ихэмсэг атлаа цаанаа л бардам зан төрх, өөртөө итгэлтэй байдлыг нь гүн шингээснээр онцлог хэдий ч өнгө зохицлын хязгааргүй сэтгэлгээг тусгажээ.

Учир нь халх үндэсний хувцасны өнгө төрх ба хойно нь байрлах хивс, аравч зэргийн наана цааныг гайхамшигтайгаар илэрхийлж чадсанд оршино.

Наана байгаа зүйл гэрэлтэй байхад цаана байгаа биет сүүдэртэй байж гэмээ орон зай нь шийдэгддэг. Энэхүү орон зайн онол зурагт шууд туссаны дээр гэрэл сүүдрийн зөв шийдлээр зохиомжилжээ. Нүүрэн дээр нь гэрэл тусгаснаар эмэгтэйн нүүрийг шууд харах бололцоо олгосон ба зүүн гар, буйдангийн түшүүр зэргийг нүүрний адил гэрэл тусгасан нь зохиомжийн доод хэсгийн орон зайг шийдсэн байна.

Халх үндэсний хувцсаар гоёсон жүжигчин эмэгтэйд элдэв хээ угалзаар дүүрэн хивс, аравчны урд суулган гэрэл сүүдрээр нь орон зайг тусгаж өгчээ. Чээж, мөрний хөдөлгөөнийг урагш харуулан ерөнхий биеийн хэлбэрийг хажуу тал руу нь налуулсан нь зохиомжийн зөв шийдэл болсон байна.

Г.Одон, “Улз голын малчин”, 1968он

Энэхүү хөргийн гол дүр нь Дорнод аймгийн Баян Дун сумын хөдөлмөрийн баатар, малчин Дарийг дүрсэлсэн аж. Үндэснийхээ хувцас, малгайтай Буриад өвгөнийг зурахдаа зүүн тал руу суулгаж нүүрэн талд нь агаар өгсөн нь зохиомжийн зөв шийдэл болсон байна. Мөн уг хөрөгт тухайн хүний зан араншинг шууд уншигдахаар дүрсэлснээр онцлог.

Эгц шийдэмгий харах нүдний цаана бодлогошронгуй, хурц дүрсэлсэн нь зуруулж буй хүний темперамент, байгаа байдлыг хурц шийдсэнтэй холбоотой юм.

Зохиомжийг эгц өөдөөс нь бус хажуу тийшээ налуулан суулгасан нь орон зайн зөв шийдэл болсон ба биеийн хэлийг нүүрний хэлтэй төгс хосолсноороо онцлогтой.

Зураг 10

Г.Одон, “Улз голын малчин”, 1963



Л.Бавуудорж “Эх” 1992он, 85x115

Хүн ба ертөнцийн үзэгдэл байгалийн юмсын өнгө, дүрсийн зохиролдох сайхныг мэдэрч, тэдгээрийг дүрсэлжилэрхийлэх урлахуйн сэтгэлгээ бүрэлдэн тогтсон нь оюуны хөгжилд гарсан том дэвшил юм. Тэрхүү дэвшилд бодит болон

бодит бус олон урсгал, сэдэв жанраар хөгжсөн ба тэр бүрд уянгын халил тодорхой хэмжээгээр үргэлж тусдаг. Зурагт гүн утга агуулга, далд онжит дүрслэл, хэний ч тааварлашгүй зохиомж гэх мэт нь шинийг эрэлхийлэх санаа бүр чухал ач холбогдолтой боловч хүний сэтгэлийн утсыг хөндөх нь нэн чухал. Харааны яруу найраг гэгддэг зураг бүр сэтгэлийн утсыг хөндөх хэдий ч уянгын халил илүүтэйгээр зүрхэнд тусдаг. XX зууны монголын уран зургийн хөгжлийн өнгө төрхөд реалист арга ажиллагаагаар зурсан эмгэний дүр хүч түрэн орж ирсэн билээ. Захиа барин нулимс нь мэлтэлзэх түүний нүднээс гуниг тээн, аврал ирэх мэт харах нь үзэгчдэд нэгийг бодогдуулдаг.

Зураг 11

Л.Бавуудорж, “Эх”, 1992 он



Судлаачид гол дүрийг цэргээс ирэх хүүгээ хүлээн буй хэмээн бичдэг ба зарим нь хүү нь насан эцэс болсныг мэдсэн эмгэнэлт дүр хэмээн тодотгосон байна. Харин өчүүхэн миний өнцгөөс харахад гол дүрийн эмгэний дүрийг ойлгох, нууцыг тайлах зангилаа нь хойно буй цагаан ботго юм. Цагаан ботго эмгэн лүү гунигтайхан ширтсэн нь түүний хүлээсэн хүнийг харуулсан мэт. Гэвч ботгыг гадаснаас уяснаар очих хүслэн байвч хясах золыг илтгэж чаджээ. Үүнээс үзэхэд эмгэн, ботго хоёулаа гол дүр бөгөөд энэхүү эмгэнэлт үзэгдлийг арын фон, өнгөөр улам баяжуулжээ. Тухайлбал уйтгар гунигийг хав харанхуй тэнгэрээр төлөөлүүлэн, зэгэл шаргал газрыг уусган холбосон зэрэг нь утга санаанд хүч болон чимэгджээ.



XX зуунд мөнхөрсөн “Self-portrait”

Self-portrait буюу өөрийн хөргийг урлах үйл явц нэн эртний уламжлалтай. Дэлхий дахинд ихэнх зураачид өөрийн хөргийг бүтээлдээ мөнхөлсөн

Зураг 12

Н.Цүлтэм “Өөрийн хөрөг”



байдаг ба хамгийн их өөрийгөө зурсан зураач бол Винсент Ван Гог юм. Харин манай оронд XX зуунд тосон будгийн арга ажиллагаа гүнзгийрэн нэвтэрсэн үед өөрийн хөргийг зурах нь элбэгшсэн. Тухайлбал: зураач Н.Цүлтэм, О.Цэвэгжавын хөргүүд юм. Ням-Осорын Цүлтэм нь нам, төр, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог,

удирдах албан тушаалд олон удаа сонгогдон ажилласан нийгмийн зүтгэлтэн байсан юм. Тиймдээ ч өөрийн хөргийг хурц ширүүн төрх, донжлог хийгээд төлөв даруу хувцаслалтаар дүрсэлжээ. Харин зураач О.Цэвэгжав өөрийн хөргийг эгэл жирийн уран бүтээлчийн дүрээр харуулахыг зорьсон юм. Тамхи зуун, одон зүүж зураг зурж байгаагаар дүрсэлснээс гадна цагаан цамц, дипломат хувцас өмсгөсөн нь тухайн үеийн сэхээтэн багшийн дүрийг давхар агуулжээ. Ийнхүү уг хоёр хөрөг бүтээлүүд нь зураач өөрийгөө үзэгчдэд ямар өнцгөөс харуулахыг хүсэж буйг тольдсоноороо онцлог юм.

Буддын философид хүний мөн чанарыг Дүрсийн цогц, Сэтгэхүйн цогц, Хуран мэдэхүйн цогц, Хуран үйлдэхүйн цогц, Тийн мэдэхүйн цогц гэсэн “Таван цогц” хэмээн тайлбарладаг. Эдгээрээс дүрсийн цогц гэдэгт хүний нүд, чих, хамар, хэл, бие гэсэн таван эрхтнээрээ ертөнцийн юмс үзэгдлийн дүрс, дуу, үнэр, амт хүртэхүйн таван шинжийг илрүүлж чадна гэж үздэг. (Сайхансүвд, 2003, х.3)

Хүнийг дүрслэхэд мөн чанар дотоод сэтгэхүй, бодол санаа, зан төрх гээд олон зүйлийг нээн харуулах нь нэн чухал. Профессор Ц.Эрдэнэцог хөрөг зургийг “Хүний дүр гэдэг нь туулсан амьдралынх нь толь юм. Тийм учраас хүний хөргийг зурна гэдэг бол төстэй зурах асуудал биш, хүний бүхэл амьдралыг нь илэрхийлж буй урлагийн төрөл юм. Мөн нийгмийн байдлыг хүний нүүрний төрхөөр нь илэрхийлж болно” (Эрдэнэцог, 2006, х. 26) хэмээн тайлбарлажээ.

Дээрхээс үзэхэд хүний дүрслэл дэх амин

сүнс нь тухайн хүний дотоод сэтгэлгээний илрэл бөгөөд зурж буй зураач түүнийг хэрхэн мэдэрснээр бүтээлийн үнэ цэнэ оршдог. Өөрөөр хэлбэл зуруулж буй хүн зурж буй хүн хоёрын харилцан шүтэлцээнд тулгуурладаг юм. Хөрөг зураг нь зөвхөн зуруулагчийн дүр, байдлыг танигдахаар зурахын тулд бүтээдэг биш, харин хүний амьдралын байдал, ертөнцийг хардаг нь гадаад дүрээр нь үзүүлдгээрээ онцлог юм. Хөрөг зурагт мөн түүхэн тодорхой цаг үеийн байдлыг үзүүлдэг зуруулагчийн нүүрний төрх байдал, ямар цаг үед амьдарч байсан гэдгийг бас илэрхийлдэг. Хөрөг зурахдаа эхлээд хүний биеийн галбир зүйн хуулийн дагуу хүний нүүрний бүтэц сэтгэлийн булчингийн тогтолцоо, хүний нүүрний эрхтнүүд хөмсөг, нүд, хамар, уруул эрүү хоорондоо ямар ямар хэмжээтэй байдгийг галбирын анатомийн хуулийн дагуу судална.

Хөрөг нь эрт дээр үед уран барималд эхлэн үүсэж дараа нь зураасан болон уран зурагт нэвтэрчээ. Хөргийн төрлийг:

- Ёслолын (хүнийг гол төлөв бүтэн биеэр дүрсэлсэн) -Ёслолын хөргийг уран барилга, байгальтай хослуулан бүтээх нь түгээмэл.
- Камерын буюу хязгаарлагдмал /ихэвчлэн хүний толгой, чээж дүрслэгдэнэ/ гэж ангилна. (Сонинтогс.Э нар.2016, х.79). Камерын хөргийг голдуу цулгүй дэвсгэрт дээр бүтээгдэг нь зураач, натур хоёрын итгэлцлийн харилцааг илэрхийлнэ.

Хүний бие тун уян хатан төдийгүй орон зайн янз бүрийн байрлалд оршдог. Хүний биеийн хөдөлгөөнийг нарийвчлалтай дүрслэхийн тулд түүнийг анхааралтай ажиглан, бие махбодын тогтолцоо, анатомийн зохих мэдлэгтэй байх байх ёстой.

- Хүний биеийн яс, булчин цөмөөрөө бие биеэсээ хамааран хөдөлдөг бүтэцтэйн дээр гурван хэмжээст тогтолцоог бүрдүүлдэг юм.
- Хүн зурах арга зүйн удирдамжийг авч үзвэл (Г.Одон нар. 1988, х.47):
- Хүний биеийн ерөнхий галбир, түүний тэгш хэмийн тэнхлэгийн шугам, хөдөлгөөний тэнцвэр, зогсолтын төв, туулах цэгүүдийг юуны өмнө олж тэмдэглэх явдал юм.
- Хүний биеийн эрхтнүүдийн харьцааг зөв тодорхойлох
- Биеийн эзлэхүүнт хэлбэр, бие бүтцийн ба хөдөлгөөний амьд холбоо гунхалзлыг олж дүрслэх.
- Биеийн анатомийн бүтцэд анализ хийх.
- Биеийн бүрэлдэхүүний хэсгүүдийг нарийвчлан дүрслэх

- Биеийн хэсэгчлэн нягталж гаргасан зураасны ерөнхий өнгө (тон), зан төрх, хэлбэр дүрсэд нь захируулан нэгтгэж ерөнхийлөн зурж дуусгах дарааллаар дүрсэлдэг юм.

Хөргийг зурахдаа эхлээд хүний биеийн галбир зүйн хуулийн дагуу нүүрний бүтэц сэтгэлийн булчингийн тогтолцоо, хүний нүүрний эрхтнүүд хөмсөг, нүд, хамар, уруул эрүү хоорондоо хэр зайтай оршдогийг анатомийн мэдлэгийн хүрээнд судална. Дараа нь тухайн формат дээр хэр байрлуулах, дүрийг хэрхэн сонгох, сонгосон дүрээ яаж илэрхийлэх нь зураачийн мэдрэмжийн цогц шийдлээр бүтээгддэг билээ. Зарим зураачид толгойн хэмжээг арай бага авдаг ба энэ нь зохиомжийн зөв харьцаа болдог хэмээн үзсэн байдаг.

Хөрөг зурагт хүний хөдөлгөөг чухал үүрэгтэй. Тухайлбал: Мөр, чээж, толгой зэрэг биеийн хэл нь нэг шугамд тэгш зохиомжилбол уйтгартай явцуу харагдах жишээтэй. Хөндлөн шугамыг өөр, өөр талаас нь хөдөлгөөнтэй зохиомжлох нь тухайн хөргийг хэмнэлтэй болж харагдуулдаг байна. Хөргийг дүрслэхдээ бүтэн, хагас бие /өвдгөөр тасалж зурах/, чээж хөргийн /нүүр, толгой, мөр/ гэх мэт олон талаас нь таслан зурж болно.

Хүний нүүрний эд эрхтэн бүр нь сэтгэл зүйн олон талт үзэгдлийг агуулдаг. Тэдгээр нь зурагт тусахдаа: Ам нь харьцангуй төвийг сахих үүрэгтэйгээр зурагддаг ба нүүрний илэрхийлэлд нүд, хөмсөгний оролцоо их. (Төмөрбат, 2010, х. 54).

Хөмсөг нь Гайхалтай, харамсалтай, айдас, өвдөлт, сэтгэл хөдлөл, үл тэвчих, дургүйцэл, хүлээлт, хязгааргүй өөрчлөлт гэх мэт олон ухагдахууныг агуулдаг байна. Уг эрхтнүүдийн тусламжтайгаар тухайн натур /зуруулж буй хүн/-ий зан төлөвийн байдлыг тодорхойлоход чухал хөшүүрэг болдог байна.

XX зууны Монголын хөрөг зургийг дараах байдлаар ангилдаг.

- Захиалгат хөрөг - Тухайн нийгэм, улс төрийн байдлаас шууд хамааран зайлшгүй албан даалгавар эсвэл хүсэлт сонирхлын дагуу бүтээгдэж буй хөрөг.
- Сэдэвт хөрөг:
 - Төр, нийгмийн зүтгэлтнүүдийн хөрөг
 - Соёл урлагийн салбарт онцгой үүрэг гүйцэтгэж байсан зүтгэлтнүүдийн хөрөг.
 - Эгэл ардын дундаас төрсөн хөдөлмөрийн баатрууд, цэрэг дайнд оролцож байсан дайчин эрсийг магтан дуулсан хөрөг
 - Нийгмийн амьдралыг тольдон бүлэг хөрөг -/гэр бүлийн гишүүд, анги бүлэг,

хамт олон, нийгмийн бүлэг этгээдүүд бүгд хамарна/

- Ажил, амжилтаараа тэргүүлж явсан залуусыг бусдад уриалан дуудах зорилгоор дүрсэлсэн хөдөлмөрч хүний хөрөг
- Өөрийн хөрөг
- Уран сайхны хөрөг-/Зориудаар зохиомжилсон сэдвийн хүрээнд дүр бүтээлгэн дүрсэлсэн хөрөг/
- Бусад

Хөрөг зургийг дүрийн талаас ангилбал,

- Насны зааг ялгаагаар нь. /балчир, идэр настай гэх мэт/-Насны өсөлтийн дагуу биеийн харьцаанд өөрчлөлт гарч, биеийн хэсгүүд харилцан адилгүйгээр өснө.
- Хүйс /эр, эм/ -Эмэгтэй хүний толгой эрэгтэй хүнийхээс бага, нүүрний хэмжээ тархины хэсгээрээ бага боловч хүзүү нарийн, өндөр зэрэг ялгаатай байдаг.
- Дүрийн илэрхийллээр нь: Сүрлэг бадрангуй дүр нэлээдгүй зонхилдог. Уг дүрийг бүтээхэд дараах аргаар дүрсэлнэ. Үүнд:
 - Гол дүрүүдийг хэсэгчлэн үзүүлэх арга
 - Дүрслэлийн өөрийн хэсгүүдийн пропорцлон үзүүлэх арга гэх мэт

Хөрөг зургийг дүрслэлийн талаас нь:

- Бүтэн хөрөг
- Чээж хөрөг
- Толгой гэх мэтээр ангилж болно.

Хөрөг зургийг арга техникийн хувьд:

- Тосон будгийн хөрөг
- Усан будгийн хөрөг
- Харандаан будгийн хөрөг
- Пастелиар зурсан хөрөг
- Зураасан зургийн хөрөг
- Монгол зургийн аргаар зурсан хөрөг гэх мэт

Хөрөг зурагт хүний хөдөлгөөн чухал үүрэгтэй.

Тухайлбал: Мөр, чээж, толгой зэрэг биеийн хэл нь нэг шугамд тэгш зохиомжилбол уйтгартай явцуу харагдах жишээтэй. Хөндлөн шугамыг өөр, өөр талаас нь хөдөлгөөнтэй зохиомжлох нь тухайн хөргийг хэмнэлтэй болж харагдуулдаг. Хөргийг дүрслэхдээ бүтэн, хагас бие /өвдгөөр тасалж зурах/, чээж хөргийн /нүүр, толгой, мөр/ гэх мэт олон талаас нь таслан зурж болдог.

Хүний нүүрний эд эрхтэн бүр нь сэтгэл зүйн олон талт үзэгдлийг агуулдаг. Тэдгээр нь зурагт тусахдаа: Ам нь харьцангуй төвийг сахих үүрэгтэйгээр зурагддаг ба нүүрний илэрхийлэлд нүд, хөмсөгний оролцоо их юм.

Хөмсөг нь- гайхах, харамсах, айх, өвдөх гэх

зэрэг сэтгэл хөдлөлийг гүн агуулдаг ба үл тэвчих, дургүйцэл, хүлээлт, хязгааргүй өөрчлөлт гэх мэт олон ухагдахууныг илэрхийлдэг. Уг эрхтнүүдийн тусламжтайгаар тухайн натур /зуруулж буй хүн/-ий зан төлөвийн байдлыг тодорхойлоход чухал хөшүүрэг болдог юм.

Судалгааны үр дүн

Хөрөг зургийн зохиомж дүрслэлийг- хөрөг зураг дахь хоосон орон зай дүрсийн хэмнэл буюу ритм, дүрүүдийн үүрэг, түүнд нөлөөлөх хүчин зүйл бүр нь сэдэв тус бүрд харилцан адилгүй байна. Хөрөг зургийн өнгө- хөрөг зураг дахь өнгийн хоршил, өнгийн алслалтыг бүрэн тодотгох, хүйтэн дулааныг дүрүүдийн байршлаас шууд унших боломж нь гол ба туслах дүрүүдэд өөр хоорондоо ялгаатайгаар зурсан байх ба ихэвчлэн гол дүрд гэрэл өгснөөр хүнд шууд тусах боломжийг олгожээ. Хөрөг зургийн арга ажиллагаа- тосон будаг, усан будаг шороон будаг гэх мэт зурагдсан хэрэглэгдэхүүнийг анхлан харах боловч уусгалт, манаргалт, фактурлаг зэрэг олон янзын ажиллагаагаар бүтээгдсэн байна. Эцэст нь тухайн зурсан зураач дотоод сэтгэлгээний илэрхийлэл буюу ертөнцийг үзэх үзэл, бодрол, илэрхийлэх гэж буй санаа, мэдрэмж нэн чухал юм. Зуруулж буй хүнийг цаг үед нь мэдэрч түүнийгээ бүтээлдээ тусгана гэдэг нь зураачаас сэтгэл зүйчээс дутахгүй мэдлэгийг шаардах ба тэрхүү мэдрэмж өөрийн харах өнцөг хоёрын нэгдлээс хөрөг бүтээл туурвигддаг байна.

Дүгнэлт

Хөрөг бүтээлд аливаа хүний давтагдашгүй дүр төрх, зан чанар, сэтгэл санаа, онцлог шинжээр нь зогсохгүй түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, нийгэмд эзлэх байр суурийг тодотгон дүрсэлдэг. Тиймдээ ч түүхийн үнэт болохын сацуу, уран бүтээлчийн чанар чансааг тодорхойлох томоохон шалгуур болдог. Хөрөг зурна гэдэг зохиомжийн хувьд авч үзэхэд хөрөг зургийн хэд хэдэн үндэслэл байдаг. Суурь уран зурагт хөргийг зурахдаа зарим зураачид толгойн хэмжээний харьцаагаар авахад буруу гэж үздэг. Толгойн хэмжээнээс арай

бага авах нь зүйтэй гэдэг. Мөн зуруулагчийн харж байгаа харааны чиглэл рүү илүү орон зай авах нь илүү тохиромжтой гэж үздэг. Хэрвээ зургийн десбтер параллель шулуун шугамд бүх юм байрлавал уйтгартай харагддаг. Ийм учраас мөрний, чээжний, толгойны хөдөлгөөн бүгд тэнцүү биш өөр өөрийн чиглэлтэй байвал зураг илүү хөдөлгөөнтэй амьд харагддаг. Хүний биеийн хөдөлгөөнийг нэг чиглэлд, нэг шугамд авбал энэ нь амьдрал хөдөлгөөнгүй уйтгартай болно. Ийм учраас сууж байгаа байрлал, таазны хөдөлгөөн, чээжний хөдөлгөөн, бүх зүйлстэй хөрөг зохицолдож зөв байрласан байх ёстой.

XX зуунд Монголд ардын хувьсгал ялснаар феодализмаас социализмд шилжсэн нь дүрслэх урлагийн бүтээл бүрийг уриалан дуудсан хэв шинж рүү хөгжих алхам болж өгсөн. Тиймдээ ч хөрөг зурагт төр, нийгмийн зүтгэлтний хөргийн хөгжил үнэтэй байр суурийг эзэлсэн байдаг. Тухайн үед дүр байдлаар тодруулахын тулд зориуд бараан дэвсгэрт дээр зурдаг байсан бол одоо үед энэ уламжлал шинэчлэгдэж амьдрал дотор нь зурах, гэгээлэг дэвсгэрт дээр зурах, эсвэл зориуд байрлуулсан зохиомжийн дэвсгэрт дээр зуруулагчийн хөргийг уядуулах шинэ арга хэлбэр хөгжсөн байна. Хөрөг зураг нь зуруулж буй хүний дүр төрхийг дотоод гоо сайхантай нь дүрсэлдэг ба ажил амьдрал, нийгэмд эзлэх байр суурь, тухайн орчинтой нь хослуулан зурдгаараа онцлогтой юм.

Ашигласан материал

- Цанжид, А. (2007). Монгол улсын шинжлэх ухаан -21. Улаанбаатар
- Одон, Г нар. (1988) Хар зураг. БНМАУ. Улаанбаатар
- Сонинтогс, Э. (2016). Соёл урлагийн тайлбар толь. Улаанбаатар: Сэлэнгэпресс.
- Баяртөр, Б. (2014). Дүрслэх урлаг судлал шинжлэл. Улаанбаатар
- Төмөрбат, Ж. (2010). Уран зураг бүтээх арга ухаан. Улаанбаатар
- Эрдэнэцог, Ц. (2006). XX зууны Монголын уран зургийн өнгө зохиол. Улаанбаатар
- Сайхансүвд, Д. (2003). Буддын урлаг дахь нүдний дүрслэлийн асуудалд. Улаанбаатар.// mongolmed.mn

Some observation character and description in Mongolian portrait at XX century

T.Selenge

*Mongolian National University of Education,
School of Fine Art and Technology, Fine Art department*

Abstract

Portrait painting is a genre in painting, where the intent is to depict a human subject. The term 'portrait painting' can also describe the actual painted portrait. Historically, portrait paintings have primarily memorialized the rich and powerful. Over time, however, it became more common for middle-class patrons to commission portraits of their families and colleagues. Today, portrait paintings are still commissioned by governments, corporations, groups, clubs, and individuals. In addition to painting, portraits can also be made in other media such as prints (including etching and lithography), photography, video and digital media. I study those subjects to my article. Therefore, I have studied Mongolian famous portraits paintings, their meanings, and how Mongolian famous portraits have been understood. End of my article: Mongolian portrait paintings have the unique position, character, emotion and character of any individual, not only in the history and role of society. Even so, it can be seen as a valuable criterion, as well as a criterion for determining the quality of the artist.

Finally, the painter is the expression of inner thinking, the worldview, the thought, and the idea that is to be expressed. Inserting a pictured person in a timely manner and incorporating it into the workplace means that an artist needs knowledge from a psychologist, and the senses of that feeling are made from a combination of his view angle and portrait creation.

Key words

Portrait, Method of interpretation8 characters, painter.